


Батлав: Дундговь аймаг,
Дэлгэрцогт сумын
Засаг дарга  М.Баярсүх

Батлав: Мандал харш ХХКомпаны
захирал  Т.Базардар

Дундговь аймаг, Дэлгэрцогт сумын хүн эмнэлгийн хуучин барилгын засварын
зураг төсөл боловсруулах ажлын гэрээ.

2021 он 02 сар 23 өдөр

Дугаар.01

Мандалговь хот

Нэг: Нийтлэг .

1.1 Нэг талаас: **Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГазрыг** төлөөлж **Тамгын газрын дарга** ажилтай **С. Нарантунгалаг** / цаашид захиалагч гэх / нөгөө талаас **"Мандал харш" ХХК**-ийг төлөөлж, **инженер** ажилтай **А.Бямбаа** /цаашид гүйцэтгэгч гэх / бид харилцан тохиролцож **2021 оны 03 сарын 23** -нд энэхүү гэрээг байгуулав.

1.2 Зураг төсвийн үнийг "ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ БД81-16-12"-ийг үндэслэх бөгөөд энэхүү ажлын зураг төсвийн үнэ **2000000 /Хоёр сая /** төгрөг байхаар тохиролцов.

1.3 Зураг төсвийг **2021 оны 03 сарын 13-ны** өдрөөс эхлэн **30** хоногт багтаан хийж захиалагчид хүлээлгэн өгнө.

1.4 Энэхүү гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудын хүлээсэн үүрэг бүрэн хэрэгжсэнээр дуусгавар болно.

Хоёр: Захиалагчийн эрх үүрэг

2.1 Захиалга нь засварын ажлын даалгавар /тодорхойлолт/, зураг төсөлд тусгах материал тоног төхөөрөмж зэргийг албан бичгээр гүйцэтгэгчид хүргүүлнэ.

2.2 Хэрэв захиалагч нь засварын ажлын тодорхойлолтыг нарийн гаргаж чадахгүй бол гүйцэтгэгчтэй хамтран хийх хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд гүйцэтгэгчээс томилогдсон мэргэжилтний албан томилолтын зардлыг захиалагч хариуцна.

2.3 Ажлын зураг төсөвт шалгалт хийж алдаа зөрчлийг арилгуулах эрхтэй.

2.4 Гэрээнд заасан ажлын хөлсний нийт үнийн дүнгийн **0** хувийн урьдчилгааг хоёр тал гэрээг баталж хүчин төгөлдөр болсноор төлөх бөгөөд ажлын зураг төсөв дуусмагц гэрээг дүгнэж үлдэгдлийг олгоно

2.5 Гүйцэтгэгчийн буруугаас зураг төсөвт алдаа гарсан тохиолдолд захиалагч нь нэмэлт үнэ төлбөргүйгээр засуулж авах эрхтэй.

Гурав: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1 Гэрээнд заагдсан ажлыг Монгол улсын "Барилгын тухай хууль" болон барилгын зураг төсөл зохиоход мөрдөж буй норм, дүрэм бусад холбогдох техникийн баримт бичгийн дагуу чанартай боловсруулан тус бүр нь 2 хувь ажлын зураг, төсөв хүлээлгэн өгнө.

3.2 Гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх явцад гарсан техникийн асуудлыг цаг тухайд нь захиалагчид уламжлах шуурхай шийдүүлэх ажлыг зохион байгуулахаас гадна техникийн нөхцөл гаргуулахад захиалагчтай хамтран ажиллана.

3.3 Гүйцэтгэгчийн буруугаас болж зураг төсөвт гарсан алдааг үнэ төлбөргүй, цаг хугацаанд нь шуурхай засаж өгнө.

3.4 Зураг төсөв хийж байх явцад захиалагчийн талаас ажлыг зогсоох санал гаргасан тохиолдолд хийгдсэн ажилд тохирох үнэ хөлсийг нэхэмжлэх эрхтэй.

Дөрөв: Харилцан хүлээх үүрэг хариуцлага.

4.1 Гүйцэтгэгч нь зураг төслийн хувьд мэргэжлийн үйлчилгээгээр хангаж, байх шаардлагыг хүлээх болно. Захиалагч нь зураг төсөл зохиох шаардлагыг хангах бүх бичиг баримтыг бүрдүүлж өгнө.

4.2 Барилгын ажлыг зохих хугацаанд нь эхлүүлэхийг эрхэмлэн зураг төслөөс хамаарсан саатал гаргахгүйн төлөө нэгэн зорилго чиглэлтэй ажиллана.

4.3 Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй үед маргааныг зөвшилцлийн аргаар найрсгаар шийдвэрлэхийн төлөө чармайн ажиллана. Ингэж чадахгүйд хүрвэл хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж, гарах зардлыг хохирол үүсгэгч тал хариуцна.


4.4 Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж:

Дэлгэрцогт сумын ЗДТГазрын

дарга



С.Нарантунгалаг

ТӨРИЙН БАНК

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Мандал харш ХХК-д
инженер ажилтай

 А.Бямбаа

ХААН БАНК

Дансны дугаар:

Утас:

Дансны дугаар: 5450478216

Утас: 99599682

Гэрээ дүгнэсэн тэмдэглэл

2021 оны 04 сарын 22

№ 01

Сайнцагаан сум

Дундговь аймаг, Дэлгэрцогт сумын хүн эмнэлэг, "Мандал харш" ХХК-ны хооронд 2021 оны 3 сарын 23 —ны өдөр байгуулсан тус сумын хүн эмнэлэгийн хуучин барилгын засварын зураг төсөв хийх ажлын 01 тоот гэрээний биелэлтийг дүгнэв.

Гүйцэтгэгч "Мандал харш" ХХК нь гэрээнд заагдсан зураг төсвийг 2021 оны 04 сарын 22 ны өдөр хүлээлгэн өглөө.

Захиалагч тал дээрх зураг төсвийг хүлээн авч танилцаад хийсэн зураг төсөв бидний өгсөн санал, холбогдох норм дүрмийн дагуу хийгдсэн байх тул гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзэж зураг төсвийн үнэ 2000000 / Хоёр сая / төгрөгийг төлөхийг зөвшөөрөв.

Зураг төсвийн чанар, гүйцэтгэх хугацааны талаар ямар нэг маргаан гараагүй болно.

Захиалагч зураг төсвийн үнийг 2021 оны 6-р сард багтаан төлж гэрээний үүргээ бүрэн биелүүлэхээр тохиролцов.

Дээрхи зураг төсвийн үнийн төлбөр хийгдсэнээр гэрээг дуусгавар болсонд тооцохоор талууд харилцан тохиролцов.


Гэрээ дүгнэсэн:


Захиалагчийг төлөөлж:

Дундговь аймаг, Дэлгэрцогт сумын
ЗДТГазрын
дарга  С.Нарангунгалэг /



Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Мандал харш" ХХК-ны
инженер
 / А.Бямбаа /



Зураг төсөв хүлээлцсэн акт № 01

2021 оны 04 сарын 22 өдөр

Мандалговь хот

- 1, Барилга байгууламжийн нэр, хүчин чадал: **Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүн эмнэлгийн хуучин барилгын засвар.**
- 2, Зураг төслийн ажлын гэрээний дугаар, үнэ: Гэрээ 01 үнэ 2000000 төгрөг.
- 3, Зураг төсөл боловсруулсан хугацаа: 2021,03,23 – 2021,04,22 хооронд.
- 4, Зураг төслийн байгууллага: **Мандал харш ХХК.**
- 5, Зургийн шифр: **МХ-02/2021.** төсвийн шифр **МХ-03/2021**
- 6, Зургийн иж бүрдэл 15 хуудас, 2 хувь.
7. Төсвийн иж бүрдэл 25 хуудас, 2 хувь.

Зураг төсвийг хүлээн авсан:Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын
ЗДТГазрын дарга

С.Нарантунгалаг

Зураг төсөв хүлээлгэн өгсөн:

Мандал харш ХХКомпаны инженер

А.Бямбаа